



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хишигдэмбэрэлийн ТЭМҮҮЖИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-60, Факс: 32-70-16
E-mail: temuujin@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025-06.12 № УИХ-03/4228
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их хурал дахь Ардчилсан намын бүлгийн болон Улсын Их Хурал дахь бүлэггүй цөөнхийн нэр бүхий Улсын Их хурлын гишүүд санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ТЭМҮҮЖИН

О.ЦОГТГЭРЭЛ

Б.ЖАРГАЛАН

Н.ЛОДОЙСАМБУУ

0. 



О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

О.АМГАЛАНБААТАР

Ц.БААТАРХҮҮ



Д.БАТБАЯР

Ж.БАТСУУРЬ

Х.БАТТУЛГА



П.БАТЧИМЭГ

Ж.БАЯРМАА



Ж.БАЯСГАЛАН



Б.БЕЙСЕН



Х.БОЛОРМАА



Ш.БЯМБАСҮРЭН



А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

С.ГАНБААТАР



Д.ГАНБАТ



Л.ГАНТӨМӨР




Д.ЖАРГАЛСАЙХАН




Л.МӨНХБАТ



Л.МӨНХБАЯСГАЛАН



П.МӨНХТУЛГА



Ц.МӨНХТУЯА



Э.ОДБАЯР



С.ОДОНТУЯА



Г.ОЧИРБАТ



Б.ПУНСАЛМАА



Б.ПҮРЭВДОРЖ



Р.СЭДДОРЖ



Ц.ТУВААН



Б.ТҮВШИН



Г.ХОСБАЯР



Д.ЦОГТБААТАР



С.ЦЭНГҮҮН

Ө.ШИЖИР



Д.ЭНХТУЯА

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН

Б.БАТБААТАР



Ж.ЗОЛЖАРГАЛ

А.УНДРАА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хишигдэмбэрэлийн ТЭМҮҮЖИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-60, Факс: 32-70-16
E-mail: temuujin@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.06.10 № 44Х-03/7146
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргав.

Хавсралт //хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ТЭМҮҮЖИН



БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ТЭМҮҮЖИН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсад 1989 оны сүүлчээс нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийн үйл явц өрнөж, Ардчилсан хүчний эвлэл, холбоод үүсэж байгуулагдсан нь улс төрийн олон намууд бий болох эхлэл тавигдаж, үүний үр дүнд манай оронд нэг намын тогтолцоог халж, ардчилсан чөлөөт сонгуулийг 1990 оны 7-р сарын 29-ний өдөр зохион байгуулсан түүхтэй.

Энэ сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан БНМАУ-ын Ардын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсан бөгөөд ардчилсан, шинэ Үндсэн хуульд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална", "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" хэмээн зааснаар манай улс байнгын ажиллагаатай нэг танхим (нийтийн танхим) бүхий парламентын Бүгд найрамдах улс болсон төдийгүй парламентын ардчиллыг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан явдал болсон юм.

Монгол Улсын Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1-д заасанчлан Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага байна. Ерөнхий сайд нь Улсын Их Хурлаас томилогдож, түүний шууд хяналтад үйл ажиллагаагаа явуулах нь парламентат ёсны гол илэрхийлэл болно. Парламентын ардчилал нь нээлттэй, тэгш, чөлөөт мэтгэлцээн, үзэл бодлын өрсөлдөөнөөр тодорхойлогдох бол парламентат ёс нь Парламентаас Ерөнхий сайдыг томилж, хянаж, хариуцлага тооцоход чиглэдэг билээ.

Монгол Улсын Их Хурал нь 126 гишүүнтэй, төрийн эрх барих дээд байгууллага боловч Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхимд Улсын Их Хурлын бүрэлдэхүүнээс гадна Ерөнхий сайд тусгайлсан суудал засуулж, хуралдаан даргалагчийн түвшинд танхимын хойморт байрлаж буй нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчимд үл нийцэж байна.

Тиймээс парламентын ардчиллыг баталгаажуулахын тулд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан Улсын Их Хурал дахь олонх ба цөөнхийн тэгш мэтгэлцээнээр явагддаг, чуулганд гишүүд сонгогч иргэдээ төлөөлөн, байр сууриа нээлттэй илэрхийлж, чөлөөтэй ижил түвшинд мэтгэлцэхийн сацуу, хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурлын бүрэн эрх халдашгүй хэрэгжих парламентат ёсны үндсэн зарчмыг хамгаалахын тулд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

1.2.Практик шаардлага

Парламентын танхимын дотоод зохион байгуулалт, суудлын байршил, хуваарийн үндсэн зарчим, онолын тайлбар нь тухайн орны улс төрийн тогтолцоо, Үндсэн хуулийн байгуулалт, ардчиллын хөгжлийн загвар, хэв маягтай шууд холбоотой байдаг. Онолын хувьд дараах зүйлсийг тайлбарладаг. Үүнд:

Парламентын нийтийн танхимын гол философи нь засгийн бүх эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй гэдгийг бэлгэддэг. Нийтийн танхим дахь суудлын байршил нь олонхийн эрх мэдэл ба цөөнхийн хяналт, хариуцлагын илэрхийлэл төдийгүй хуралдаж шийдвэр гаргах үндсэн зорилгод зориулагдсан байдаг. Танхимд онцгойрох "спикер"-ын суудал нь хууль тогтоох эрх мэдлийг тэнцвэртэй, сонирхолын зөрчилгүй, хуралдааны хэлбэрээр хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хурлын дэгийг сахиулах, парламентын дархлааг хамгаалах үүргийг хариуцах байдлыг илтгэдэг. Ардчиллын зарчим буюу хагас дугуй болон дугуй суудлын байрлал нь нам харгалзалгүй хэлэлцүүлэгт уриалан дуудах зорилготой бөгөөд олонхи цөөнхийн мэтгэлцээн нээлттэй өрнөх боломжийг хангана. Танхимын байрлал бол зөвхөн архитектур биш ба улс төрийн соёл, шийдвэр гаргах арга барилд шууд нөлөөлдөг байна.

Монголын Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхим нь улс төрийн чөлөөт, өрсөлдөөнт мэтгэлцээний талбар байх зарчмыг тэр бүр хангадаггүй, тэр байтугай чуулганы хуралдааны танхимын зохион байгуулалтын бүдүүвч зураг, байршлыг ямар субъект батлах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Тиймээс 1992 оноос хойш Улсын Их Хурлын дэд дарга сайн дураар уг зураглал,

байршлыг баталж ирсэн нь хамгийн сүүлд Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа баталсан нь одоо мөрдөгдөж байгаа ажээ. Тиймээс уг асуудлыг цэгцлэх үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах практик шаардлагатай гэж үзлээ.

Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслөөр Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, хуралдааны танхимын зохион байгуулалтын үндсэн зарчим, суудлын хуваарийн ерөнхий төлөвлөтийг зохицуулна. Тодруулбал чуулганы хуралдаан, танхимын зохион байгуулалт нь Улсын Их Хурлын бүрэлдэхүүн хуралдаж, ард түмнийг төлөөлөх, хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих эрхээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүд чөлөөтэй тэгш эрхийн үндсэн дээр мэтгэлцэх, байр сууриа илэрхийлэхэд зориулагдсан байх талаарх зохицуулалт байна.

Хуульд зааснаар Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь чуулган байх бөгөөд Чуулганы хуралдааны танхимын суудлын зохион байгуулалт нь төрийн эрх барих дээд байгууллага үйл ажиллагаагаа бие даасан байдлаар явуулахад чиглэгдсэн байхаар энэхүү хуулийн төслөөр зохицуулна. Мөн чуулганы хуралдаанд олонхи цөөнхийн мэтгэлцээн нээлттэй өрнөх боломжийг хангана. Чуулганы хуралдаан нь Улсын Их Хурлын нийт гишүүн буюу 126 гишүүн төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон ард түмний элчийн хувьд харилцан тэгш эрхтэй хуралдаж, хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгох зарчмыг баримтална.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийн шийдвэрлэх арга хэмжээний талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Улсын Их Хурлын батлагдсанаар нийгмийн үр дагавар нь эерэг байна. Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1, Хорьдугаар зүйл, Хорин нэгдүгээр зүйлийн 1, Хорин гурав, Хорин тав, Хорин зургаа, Хорин долдугаар зүйлд заасан парламентын ардчилал, парламентат ёсыг сэрээх, Улсын Их Хурлын олонхи цөөнх тэгш мэтгэлцэх, Улсын Их Хурлын гишүүд нийт иргэд, улсын ашиг сонирхолын төлөө нээлттэй, бие даасан байдлаар асуулт асууж, үг хэлж, байр сууриа илэрхийлэх зарчим хангагдаж, Үндсэн хуулийн дэг журамд нийцсэн улс төрийн соёл төлөвшин тогтох үр дагавартай гэж үзсэн.

Түүнчлэн, Үндсэн хуулийн Дөчиннэгдүгээр зүйлийн 1-д зааснаар Ерөнхий сайд ... төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна, Дөчиннэгдүгээр зүйлийн 2-д зааснаар Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнах хүрээнд энэхүү хуулийн төслөөр зохицуулах суудлын

хуваарилалт нь нэг талаас төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал, нөгөө талаас Улсын Их Хурлаас байгуулагдсан гүйцэтгэх засаглал, Ерөнхий сайдын ажил хэргийн харилцааг зохистой байлгахад чиглэгдэнэ.

Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийг олонхоос бүрдүүлж, Засгийн газраа бүрдүүлсэн олонхын бодлого үйл ажиллагаа нь Засгийн газрын үйл ажиллагаагаар илэрдэг бөгөөд цөөнх нь олонхийн бодлого, үйл ажиллагааны хүрээнд асуулт асууж үг хэлэх, санал дүгнэлт гаргах байдлаар харилцан тэнцвэртэй мэтгэлцэх боломжийг танхимын зохион байгуулалтаар бүрдүүлэхийг хуулиар зохицуулна.

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт нэмэлт зардал үүсэхгүй болно.

--oOo--

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална", "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" хэмээн зааснаар манай улс байнгын ажиллагаатай нэг танхим (нийтийн танхим) бүхий парламентын Бүгд найрамдах улс болсон төдийгүй парламентын ардчиллыг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан юм.

Монгол Улсын Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1-д заасанчлан Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага байна. Ерөнхий сайд нь Улсын Их Хурлаас томилогдож, түүний шууд хяналтад үйл ажиллагаагаа явуулах нь парламентат ёсны гол илэрхийлэл болно.

Парламентын ардчилал нь нээлттэй, тэгш, чөлөөт мэтгэлцээн, үзэл бодлын өрсөлдөөнөөр тодорхойлогдох бол парламентат ёс нь парламентаас ерөнхий сайдыг томилж, хянаж, хариуцлага тооцоход чиглэдэг билээ.

Монгол Улсын Их Хурал нь 126 гишүүнтэй, төрийн эрх барих дээд байгууллага боловч Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхимд Улсын Их Хурлын бүрэлдэхүүнээс гадна Ерөнхий сайд тусгайлсан суудал эзэгнэж хуралдаан даргалагчийн түвшинд танхимын хойморт байрлаж буй нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчимд үл нийцэж байна.

Тиймээс парламентын ардчиллыг баталгаажуулахын тулд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан Улсын Их Хурал дахь олонх ба цөөнхийн тэгш мэтгэлцээнээр явагддаг, чуулганд гишүүд сонгогч иргэдээ төлөөлөн, байр сууриа нээлттэй илэрхийлж, үгээ чөлөөтэй хэлдэг байхын сацуу, хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурлын бүрэн эрх халдашгүй хэрэгжих

парламентат ёсны үндсэн зарчмыг хамгаалахын тулд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Парламентын нийтийн танхимын гол философи нь засгийн бүх эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй гэдгийг бэлгэддэг. Нийтийн танхим дахь суудлын байршил нь олонхийн эрх мэдэл ба цөөнхийн хяналт, хариуцлагын илэрхийлэл төдийгүй хуралдаж шийдвэр гаргах үндсэн зорилгод зориулагдсан байдаг. Танхимд онцгойрох "спикер"-ын суудал нь хууль тогтоох эрх мэдлийг тэнцвэртэй, сонирхолын зөрчилгүй, хуралдааны хэлбэрээр хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хурлын дэгийг сахиулах, парламентын дархлааг хамгаалах үүргийг хариуцан ажиллах байдлыг илтгэдэг. Ардчиллын зарчим буюу хагас дугуй болон дугуй суудлын байрлал нь нам харгалзалгүй хэлэлцүүлэгт уриалан дуудах зорилготой бөгөөд олонхи цөөнхийн мэтгэлцээн нээлттэй өрнөх боломжийг хангана.

Танхимын байрлал бол зөвхөн архитектур биш ба улс төрийн соёл, шийдвэр гаргах арга барилд шууд нөлөөлдөг байна.

Монголын Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхим нь улс төрийн чөлөөт, өрсөлдөөнт мэтгэлцээний талбар байх зарчмыг тэр бүр хангадаггүй, тэр байтугай чуулганы хуралдааны танхимын зохион байгуулалтын бүдүүвч зураг, байршлыг ямар субъект батлах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Тиймээс 1992 оноос хойш Улсын Их Хурлын дэд дарга сайн дураар уг зураглал, байршлыг баталж ирсэн нь хамгийн сүүлд Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа баталсан нь одоо мөрдөгдөж байгаа ажээ. Тиймээс уг асуудлыг цэгцлэх үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах практик шаардлагатай гэж үзлээ.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална", "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" хэмээн зааснаар манай улс байнгын ажиллагаатай нэг танхим (нийтийн танхим) бүхий парламентын Бүгд найрамдах улс болсон төдийгүй парламентын ардчиллыг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан юм.

Монгол Улсын Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1-д заасанчлан Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага байна. Ерөнхий сайд нь Улсын Их Хурлаас томилогдож, түүний шууд хяналтад үйл ажиллагаагаа явуулах нь парламентат ёсны гол илэрхийлэл болно.

Парламентын ардчилал нь нээлттэй, тэгш, чөлөөт мэтгэлцээн, үзэл бодлын өрсөлдөөнөөр тодорхойлогдох бол парламентат ёс нь парламентаас ерөнхий сайдыг томилж, хянаж, хариуцлага тооцоход чиглэдэг билээ.

Монгол Улсын Их Хурал нь 126 гишүүнтэй, төрийн эрх барих дээд байгууллага боловч Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхимд Улсын Их Хурлын бүрэлдэхүүнээс гадна Ерөнхий сайд тусгайлсан суудал эзэгнэж хуралдаан даргалагчийн түвшинд танхимын хойморт байрлаж буй нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчимд үл нийцэж байна.

Тиймээс парламентын ардчиллыг баталгаажуулахын тулд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан Улсын Их Хурал дахь олонх ба цөөнхийн тэгш мэтгэлцээнээр явагддаг, чуулганд гишүүд сонгогч иргэдээ төлөөлөн, байр сууриа нээлттэй илэрхийлж, үгээ чөлөөтэй хэлдэг байхын сацуу, хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурлын бүрэн эрх халдашгүй хэрэгжих

парламентат ёсны үндсэн зарчмыг хамгаалахын тулд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Парламентын нийтийн танхимын гол философи нь засгийн бүх эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй гэдгийг бэлгэддэг. Нийтийн танхим дахь суудлын байршил нь олонхийн эрх мэдэл ба цөөнхийн хяналт, хариуцлагын илэрхийлэл төдийгүй хуралдаж шийдвэр гаргах үндсэн зорилгод зориулагдсан байдаг. Танхимд онцгойрох "спикер"-ын суудал нь хууль тогтоох эрх мэдлийг тэнцвэртэй, сонирхолын зөрчилгүй, хуралдааны хэлбэрээр хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хурлын дэгийг сахиулах, парламентын дархлааг хамгаалах үүргийг хариуцан ажиллах байдлыг илтгэдэг. Ардчиллын зарчим буюу хагас дугуй болон дугуй суудлын байрлал нь нам харгалзалгүй хэлэлцүүлэгт уриалан дуудах зорилготой бөгөөд олонхи цөөнхийн мэтгэлцээн нээлттэй өрнөх боломжийг хангана.

Танхимын байрлал бол зөвхөн архитектур биш ба улс төрийн соёл, шийдвэр гаргах арга барилд шууд нөлөөлдөг байна.

Монголын Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхим нь улс төрийн чөлөөт, өрсөлдөөнт мэтгэлцээний талбар байх зарчмыг тэр бүр хангадаггүй, тэр байтугай чуулганы хуралдааны танхимын зохион байгуулалтын бүдүүвч зураг, байршлыг ямар субъект батлах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Тиймээс 1992 оноос хойш Улсын Их Хурлын дэд дарга сайн дураар уг зураглал, байршлыг баталж ирсэн нь хамгийн сүүлд Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа баталсан нь одоо мөрдөгдөж байгаа ажээ. Тиймээс уг асуудлыг цэгцлэх үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах практик шаардлагатай гэж үзлээ.

Хуулийн төслөөр Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, хуралдааны танхимын зохион байгуулалтын үндсэн зарчим, суудлын хуваарийн ерөнхий төлөвлөтийг зохицуулна. Тодруулбал чуулганы хуралдаан, танхимын зохион байгуулалт нь Улсын Их Хурлын бүрэлдэхүүн хуралдаж, ард түмнийг төлөөлөх, хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих эрхээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүд мэтгэлцэх, байр сууриа илэрхийлэхэд зориулагдсан байх талаарх зохицуулалт байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь 3 зүйл, 12 хэсгээс бүрдэх бөгөөд дараах зарчмын шинжтэй нэмэлтийг оруулж байна.

- Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлд 4 хэсэг нэмж оруулснаар Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, хуралдааны танхимын зохион байгуулалт нь Улсын Их Хурлын бүрэлдэхүүн хуралдаж, ард түмнийг

төлөөлөх, хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих эрхээ хэрэгжүүлэх, улсын их хурлын гишүүд мэтгэлцэх, байр сууриа илэрхийлэхэд зориулагдсан байх зохицуулалтыг тусгалаа.

Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийг олонхоос бүрдүүлж, Засгийн газраа бүрдүүлсэн олонхын бодлого үйл ажиллагаа нь Засгийн газрын үйл ажиллагаагаар илэрдэг бөгөөд цөөнх нь олонхийн бодлого, үйл ажиллагааны хүрээнд асуулт асууж үг хэлэх, санал дүгнэлт гаргах байдлаар харилцан тэнцвэртэй мэтгэлцэх боломжийг танхимын зохион байгуулалтаар бүрдүүлэхийг хуулиар зохицуулна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Улсын Их Хурлын батлагдсанаар нийгмийн үр дагавар нь эерэг байна. Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1, Хорьдугаар зүйл, Хорин нэгдүгээр зүйлийн 1, Хорин гурав, Хорин тав, Хорин зургаа, Хорин долдугаар зүйлд заасан парламентын ардчилал, парламентат ёсыг сэрээх, Улсын Их Хурлын олонхи цөөнх тэгш мэтгэлцэх, Улсын Их Хурлын гишүүд нийт иргэд, улсын ашиг сонирхолын төлөө нээлттэй, бие даасан байдлаар үг хэлж, байр сууриа илэрхийлэх зарчим хангагдаж Үндсэн хуулийн дэг журамд нийцсэн улс төрийн соёл төлөвшин тогтох үр дагавартай гэж үзсэн.

Парламентын ардчилал хөгжсөн орнуудын хувьд парламент үйл ажиллагаа хэвийн явагдах асуудлыг нэг бус зуун жилийн өмнөөс хуульчлан төгөлдөршүүлж, улмаар парламентын танхимын зохион байгуулалтыг хэлэлцэж буй асуудал, санаачилсан хууль тогтоомжийн хүрээнд олонх болон цөөнх мэтгэлцэх боломжийг бүрдүүлж өгсөн байна. Английн Вестминстер хуралдааны танхимын зарчмыг баримталдаг улс орнуудын хувьд хууль тогтоох төрийн эрх барих дээд байгууллага хэнээс ч хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах боломжийг бүрдүүлсэн танхимын зохион байгуулалтыг анхаарч ирсэн нь сонгодог жишиг болж дэлгэрсээр байна.

Ихэнх орнуудын хувьд парламентын хуралдааны танхимын хойморт зөвхөн хуралдаан даргалагч суух ба түүний баруун зүүн талаар олонх, цөөнхийг өөд өөдөөс нь харуулсан байдлаар суудлыг хуваарилахдаа олонх, цөөнхийн "лидер" (олонхын хувьд Ерөнхий сайд, цөөнхийн хувьд бүлгийн дарга)-ийн суудлыг харалдаа суухаар зохион байгуулсан нь мэтгэлцээнд харилцан тэнцвэрт байдлыг бий болгосон байдаг байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.4, 15.5, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

"15.4.Нэгдсэн хуралдааны танхимын суудал, түүний хуваарь нь Улсын Их Хурлын бүрэлдэхүүнд зориулсан байх бөгөөд танхимын хоймор хэсэгт зөвхөн хуралдаан даргалагч, хуралдаан зохион байгуулагчид зориулсан суудлыг тусгайлан байрлуулна. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор танхимын зохих хэсэгт Ерөнхийлөгчид зориулсан тусгайлан суудал байрлуулж болно.

15.5.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн зүүн гар талд олонхын бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд олонхын бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас, олонхын бүлгийн дарга, эрх барих хүчнээс сонгогдсон Ерөнхий сайд хэрэв Улсын Их Хурлын гишүүн бол түүний суудлыг дарааллуулан хуваарилна.

15.6.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн баруун гар талд хамгийн олон суудал авсан цөөнхийн бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд тус бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас цөөнхийн бүлгийн даргын суудлыг хуваарилна.

15.7.Цөөнх болсон бусад нам, эвслийн бүлгийн гишүүд, бүлэггүй цөөнхийн гишүүдийг дараагийн суудлуудад хуваарилах бөгөөд тус цөөнхийн бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд дарга, тухайн цөөнхийн бүлгийн дарга нарын суудлыг нүүрний эгнээнд тус тус хуваарилна.

15.8.Нэгдсэн хуралдааны танхимын суудлын хуваарилалтыг энэ зүйлд нийцүүлэн Улсын Их Хурлын даргын захирамжаар тогтооно.

15.9.Нэгдсэн хуралдаанд үг хэлж, мэдээлэл хийх ажлын хэсгийг Улсын Их Хурлын бүрэлдэхүүнд зориулсан суудал бүхий хэсгээс тусад нь байрлуулсан суудалд суулгах ба ажлын хэсгийн гишүүн босож үг хэлэх индэрийг уг хэсэгт байрлуулна. Улсын Их Хурлын гишүүн бус Ерөнхий сайдын суудлыг энэ хэсэгт байрлуулна.

15.10.Байнгын, дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдааны танхимыг энэ хуулийн 15.4, 15.5-д заасныг жишиг болгон зохион байгуулна."

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн дугаарыг "15.11" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг